



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/618

Мөрөн сум

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар
хэрэгжиж буй зарим төсөл арга
хэмжээг зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, 14.2.2, 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01 өдрийн ээлжит XIII хуралдааны 04 дүгээр тогтоол, 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/614 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөвт өртөг нь өндөр, тухайн жилийн санхүүжилт нь бага, үр дүн муутай, тендер шалгаруулалтыг удаа дараа зарласан боловч сонирхогч этгээд оролцоогүй зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоож, хавсралтаар баталсугай.

2. Тендер шалгаруулалтыг зогсоосон төсөл арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу олон нийтэд мэдээлэхийг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх), аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гандэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

6712011861

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын
15-ны өдрийн А/г/З-рөөт захирамжийн хавсралт

Худалдан авах ажиллагааг зогсоох төсөл арга хэмжээний жагсаалт

PHOA0007 9070354

| № | Төсөл, арга хэмжээний нэр, байршил | эхлэх хугацаа | дуусах хугацаа | Төсөвт өртөг | 2024 онд санхүүжүүлэх дүн | Тайлбар |
|---|---|---------------|----------------|--------------|---------------------------|--|
| 1 | Тоомын давааны зам засвар, арчлалт /Улаан-Уул сум/ | 2024 | 2025 | 70,000.0 | 70,000.0 | ХАА зохион байгуулаад оролцогчгүй тул амжилтгүй болсон байна |
| 2 | 1-р багийн засмал замаас "Төв гандан" хүртэлх явган хүний зам, гэрэлтүүлгийн хамт хатуу хучилттай зам барих /Мөрөн сум 1-р баг/ | 2024 | 2025 | 559,977.4 | 75,000.0 | Оролцогчгүй |
| 3 | 1-р багийн засмал замаас "Ирээдүй сургууль" хүртэлх хатуу хучилттай зам барих /Мөрөн сум 2-р баг/ | 2024 | 2025 | 960,518.7 | 10,000.0 | Оролцогчгүй |
| 4 | Дулааны шугам сүлжээний ажил /Хөвсгөл аймаг, Түнэл сум/ | 2023 | 2024 | 15,000.0 | 15,000.0 | Тендер зарлаагүй |
| 5 | Урандеш хүүхдийн зуслангийн байруудын их засвар | 2024 | 2025 | 587,957.3 | 20,000.0 | Үр дүн гараагүй |

| | | | | | | |
|----|---|-------|-------|-------------|-----------|---|
| 6 | Хогийн цэг хүртэл хатуу хучилттай авто зам тавих /Мөрөн сум/ | 2024 | 2024 | 2,885,242.7 | 20,000.0 | Тендер зарласан 2024.12.02нд нээнэ |
| 7 | Соёлын төвийн сандал /Төмөрбулаг сум | 2024 | 2024 | 10,000.0 | 10,000.0 | Хэрэгжээгүй |
| 8 | Худаг гаргах /Тариалан сум, ар тархи баг хуурай хөндий/ | 2024 | 2024 | 30,000.0 | 30,000.0 | 2 удаа ХАА зохион байгуулсан оролцогчгүй байна. |
| 9 | Нэгдсэн халаалт тавих ажлыг эхлүүлэх /Алаг-Эрдэнэ сум/ | 2024 | 2025 | 400,000.0 | 200,000.0 | 2 удаа ХАА зохион байгуулсан 2024.11.15нд нээнэ |
| 10 | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн хөл бөмбөгийн талбайн засвар | 2,024 | 2,025 | 236,771.3 | 120,000.0 | хэрэгжээгүй |
| 11 | Спорт заалны засвар /Хатгал тосгон/ | 2,024 | 2,024 | 179,565.0 | 100,000.0 | 2024.11.14нд нээнэ |

_____ооо_____